


ОНЫ “ОТГОН” НОМ

*Д.Золбоо**

Үүсгэн байгуулагдаад 40 дэх жилийнхээ нүүрийг үзэж буй ШУА-ийн ууган хүрээлэнгүүдийн нэг манай хүрээлэн энэ онд өмнөх жилүүдийн нэгэн адил эрдмийн бүтээлийн ургац арвинтай жил болон өнгөрлөө. Үүний нэгэн баталгаа нь Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор, дэд профессор, шинжлэх ухааны тэргүүний ажилтан Ч.Батцэцэг олон жилийн судалгааны ажлынхаа үр дүнд тулгуурлан “Монгол Улсын хил залгаа бүс нутаг” сэдэвт нэгэн сэдэвт бүтээлийг шинэ оны өмнөхөн уншигч олныхоо гар дээр өргөн

барилаа. Тэрээр сүүлийн хорь гаруй жилийн турш энэ сэдвээр тухайлан ажиллаж байгаа манай цөөхөн судлаачийн нэг бөгөөд 2004 онд “Монгол Улс БНХАУ-ын харилцаанд Өвөр Монголын Өөртөө Засах Орны эзлэх байр суурь (XX зууны дунд үеэс XXI зууны эхэн хагас)” сэдвээр докторын (Ph.D) зэргийг амжилттай хамгаалсан юм. Уг бүтээлийг түүний номын багш манай нэрт түүхч, шинжлэх ухааны гавъяат ажилтан, доктор профессор Л.Жамсран хянан тохиолдуулсан ажээ.

“Монгол Улсын хил залгаа бүс нутаг” хэмээх шинэ бүтээл нь оршил, 2 бүлэг, дүгнэлт гэсэн хэсгээс бүрдэх 8.5 хэвлэлийн хуудас бөгөөд зохиогч манай улстай хил залгаа бүс нутгийн ард түмний түүхэн хөгжил, хил орчмын газруудын хэлхээ холбоо, харилцан ашигтай байх, хамтын ажиллагааг илүү бодитойгоор хөгжүүлэх боломжийг нээн илрүүлэх, тэдгээрийн эерэг сөрөг тал, үндэсний аюулгүй байдал, ирээдүйн төлөв байдлыг цогцоор тодорхойлох зорилгыг өмнөө тавьсан байна. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс (БНБУ) гэсэн нэгдүгээр бүлэг нь ОХУ-ын БНБУ-ын түүхэн хөгжил, Монгол Улс ОХУ-ын БНБУ-ын харилцаа, хамтын ажиллагаа, Хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа гэсэн хэсгээс бүрдэх ажээ. Харин

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

хоёрдугаар бүлэг нь БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны түүхэн хөгжил, БНХАУ-ын “Баруун бүс нутгийг хөгжлийг эрчижүүлэх бодлого дахь ӨМӨЗО, Монгол Улс БНХАУ-ын харилцаанд ӨМӨЗО-ны эзлэх байр суурь гэсэн хэсгээс бүрдэж байна.

Өнөөдөр дэлхийн монгол угсаатны дийлэнх нь Монгол Улс болон түүний өмнө, хойд хэсгээр хил залган оршдог БНХАУ, ОХУ гэсэн хоёр их гүрний зах хязгаар болсон энэхүү бүс нутгаар оршин суудаг билээ. Тиймдээ ч энэ бүс нутгийн түүхэн хөгжлийн тойм, өнөөгийн бодит байдал, бүс нутгийн харилцааны чиг хандлагын талаар жирийн олон ард иргэдээс эхлэн төрийн бодлогын хэмжээнд анхааран ажиглаж байдаг. Манай улсын гадаад харилцааны түүхийн судлалд өнөө цагийн Монгол Улсын хил залгаа бүс нутагт оршин суух язгуур угсаа нэгт монгол үндэстний асуудал, ӨМӨЗО болон БНБУ онцгой байр эзэлдэг. Тиймдээ ч “Монгол Улсын хил залгаа бүс нутаг” ном нь энэ бүс нутгуудын талаар тус бүрд нь задлан дүгнэж, нэгдсэн нэг цогц хэлбэрээр гарч байгаа судалгааны анхны бүтээлийн нэг болж байгаагаараа ихээхэн онцлог юм. Даяаршлын өнөөгийн нөхцөлд бие даасан тусгаар нэгэн үндэстний хувьд хүн ам, удмын сангаа хадгалах, нүүдлийн соёл иргэншил, түүх, хэл бичиг, ёс заншил өв уламжлалаа авч үлдэхийн тулд хил залгаа монгол угсаатны дунд соёлын хүрээгээ тэлж, хил хязгаараа бэхжүүлэх зорилт тулгарч байгаа талаар өөрийн санаагаа дэвшүүлжээ.